

БНХАУ дахь Эвэнк үндэстний бүжгийн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал

Чулууны Сачира 

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ sachira2024@163.com

Жамьяндоржийн Эрдэнэхорлоо 

Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Тус өгүүлэл нь БНХАУ-ын Эвэнк үндэстний орчин цагийн тайзны бүжгийн үе үеийн төлөөлөх чанартай шилдэг бүтээлүүдийг судалж дүн шинжлэл хийхэд чиглэсэн болно. Ингэхдээ нэрт бүжиг дэглээч Жя Зуо Гуаны дэглэсэн бүтээл, орон нутгийн “Улаан мөчир”-ийн тайзнаа тоглосон бүтээл, Өвөр монголын урлагийн сургуулийн багш нарын дэглэсэн бүтээл гэж гурван хэсэгт ангилан харьцуулалтын арга, сэдэвт холбогдох ном, судалгааны бүтээлд баримт бичгийн шинжилгээ хийж нэгтгэн дүгнэсэн болно.

Судалгаанаас үзэхэд, 1950-аад оноос Эвэнк үндэстний бүжгийн бүтээлийг тайзнаа тоглож эхэлсэн байна. Нэрт бүжиг дэглээч Жя Зуо Гуан нь Эвэнк үндэстний тайзны бүжгийн суурийг тавьж өгсөн бөгөөд судалгаанд суурилж дэглэсэн түүний бүтээлүүд нь уран бүтээлчдэд жишиг болж өгсөн байна.

1960-аад оноос Эвэнк үндэстэн оршин суудаг нутгийн “Улаан мөчир”-т Эвэнкчүүдийн бөө мөргөл, ан агнуур, цаа буга маллах соёл, ой тайгын амьдралыг тусгасан бүжгийн бүтээлүүд дэглэж урын санг баяжуулжээ.

Өвөр монголын урлагийн дээд сургуулийн багш нар шинэлэг зохиомжийн арга барилаар бүжигчнээс техникийн өндөр ур чадвар шаардсан бүжгүүд дэглэж Эвэнк үндэстний бүжгийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Уламжлал, шинэчлэлийн хослуулан туурвисан Эвэнк үндэстний орчин цагийн бүжгийн бүтээлүүд нь үндэстний соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх нэг арга хэрэгсэл болсоор байна.

Түлхүүр үгс: Эвэнк соёл, ардын бүжиг, тайзны бүжиг, бүжгийн дүр, хөдөлгөөн

Some issues regarding the tradition and innovation of the Evenki ethnic dance in the People's Republic of China

Sachira Chuluun ✉ 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ sachira2024@163.com

Erdenekhorloo Jamiyandorj 

School of Dance Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article focuses on analyzing representative works of contemporary stage dance of the Evenki ethnic group in China. The study is divided into three sections: the choreographic works of renowned dance artist Jia Zuoguang, the stage productions of the local «WULANMUQI» troupe, and the creations by instructors from the Inner Mongolia Arts College. Research indicates that since the 1950s, Evenki dance works began to be performed on stage. Jia Zuoguang laid the foundational framework for Evenki stage dance, and his research-based choreographic works have served as benchmarks for subsequent generations of artists. In the 1960s, the «WULANMUQI» troupe from regions inhabited by the Evenki people enriched the dance repertoire by creating works that reflected shamanic rituals, hunting traditions, reindeer herding culture, and forest life. Faculty members from the Inner Mongolia Arts College further advanced the development of Evenki dance by designing technically demanding choreographies through innovative methods, contributing significantly to its evolution. Contemporary Evenki dance works, which harmoniously blend tradition and innovation, continue to serve as vital tools for promoting and disseminating ethnic culture.

Keywords: *Evenki culture, folk dance, stage dance, dance roles, movement*

Оршил

Эвэнк бол эрт дээр үед ан гөрөө хийж, буга маллаж амьдарч байсан үндэстний үр хойчис юм. Эвэнк гэдэг нь тэдний хэлээр “Ойн иргэд” гэсэн утгатай. БНХАУ-ын Эвэнк үндэстэн нь Өвөр монголын Хөлөнбуйрын тал нутаг, Их Хянганы даваа, Хармөрөн муж (黑龙江省), Шинжиан-Уйгурын өөртөө засах орон зэрэг газар нутагт тархан суурьшсан байна. БНХАУ-ын Эвэнк үндэстэн нь “Солон”, “Олгуяа”, “Түнгүс” гэсэн гурван угсаатны бүлгээс бүрддэг. “Солон” нь Эвэнк үндэстний хүн амын 80%-ийг эзэлдэг бөгөөд Хөлөнбуйр хотын Эвэнкийн өөртөө засах хошуу, Арон хошуу, Жалан айл, Морин даваа - Дагуур үндэстний өөртөө засах хошуу, Орчооны өөртөө засах хошуу зэрэг газарт мал аж ахуй, газар тариалан эрхэлж амьдардаг. “Түнгүс” эвэнкчүүд Хөлөнбуйрын хуучин Барга хошууны Эвэнк сумын нутагт мал маллан амьдарч байна. “Олгуяачууд” Гэгээн гол хотын “Олгуяа Эвэнк үндэстний тосгон ба Их хянганы давааны өргөн уудам ой шугуйд цаа буга тэжээн, урцанд сууж, уламжлалт соёлоо хадгалсаар байна” (Содном, Гэрэл 2023, 87). “1958 оноос угсаа гарвал нэгтэй “Солон”, “Тунгус”, “Олгуяа” нар сайн дурын

үндсэн дээр “Эвэнк үндэстэн” гэж өөрсдийгөө нэрлэхээр болсон байна” (Сэрэнбат 2007, 6).

Эвэнк үндэстний бүжиг нь нүүдлийн амьдрал, ан агнуур, шашин шүтлэгтэй нягт холбоотой бөгөөд Эвэнкийн ард түмний оюун сэтгэлгээ, түүх, байгальтай харилцах харилцааг илэрхийлдэг юм. 1950-аад оны эхэн үеэс бүжиг дэглээч, судлаачид Эвэнк үндэстний ардын бүжгийг нарийвчлан судалж, судалгаандаа тулгуурлан ардын бүжгийг тайзнаа дэглэн тавих болсон. Ингэснээр Эвэнк ардын бүжиг нь мэргэжлийн чанартай тайзны урлагийн нэг төрөл болсон билээ. Орчин цагийн тайзны бүжгийг уламжлалт ардын бүжгийг шинэчлэлтэй хослуулан хөгжүүлсээр байна.

Мэргэжлийн ур чадварын өндөр түвшинд хүрсэн орчин цагийн Эвэнк үндэстний тайзны бүжгийг судлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгсөн судалгааны бүтээл хомс байгаа нь тус өгүүллийг бичих үндэслэл болсон юм.

Эвэнк тайзны бүжгийг дэглэн найруулсан шилдэг уран бүтээлүүдийн бүжгийн хөдөлгөөн, уламжлалт шинэчлэлтийг судлан, тэдгээрийн холбоог харьцуулан шинжлэн тодруулахад судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг хийхдээ орчин цагийн Эвэнк үндэстний үе үеийн шилдэг бүжгийн бүтээлд онолын үүднээс задлан шинжлэл хийж тухай тухайн бүтээлийн уламжлал, шинэчлэлийг тодруулахдаа харьцуулалтын арга ашигласан болно. Мөн сэдэвт холбогдох ном, судалгааны бүтээлд 1950-аад оноос хойш баримт бичгийн шинжилгээ хийсний дээр бүжгийн бүтээлүүдийн видео бичлэг үзэж ажиглан судалсан юм. Судалгааны үр дүнг нэгтгэж судлаач дүгнэлт хийсэн болно.

Судалгааны үр дүн

БНХАУ байгуулагдсаны дараах нийгмийн тогтолцоо, эдийн засгийн хөгжлийн нөлөөгөөр хятадын бүжгийн урлаг нь шинэ хөгжлийн шатанд гарсан байна. 1942 оны 5-р сард болсон “Янъяний соёл, урлагийн зөвлөлдөх хурал”-аар соёл, урлаг ба улс төрийн харилцааны онолыг тодорхойлсон. Тогтоолд “Соёл урлаг ард түмэнд үйлчлэх” заалт оржээ. Тус тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд “...олон уран бүтээлчид, бүжиг дэглээчид орон нутаг руу явж хээрийн судалгаа хийж эхэлсэн байна” (Хань Шяочин, Жао Чуань 2021). Тэдний нэг нь хожим нэр алдартай бүжиг дэглээч болсон Жя Зуо Гуан байв.

Жя Зуо Гуан Өвөр монголын соёлын урлагийн чуулгад (内蒙古文工团) бүжигчин, тоглолтын хэлтсийн дарга, бүжиг дэглээч Өвөр монголын дуу бүжгийн чуулгын (内蒙古歌舞团) дарга, уран сайхны удирдагч, бүжгийн багш зэрэг албан тушаалыг хашиж байжээ. 1959-1963 онд Төвийн үндэсний дуу бүжгийн чуулгын дэд дарга, урлагийн зөвлөлийн дарга, уран сайхны удирдагчаар ажиллаж байхдаа хятадын алдарт бүжиг дэглээч, багш Үү Шио Бантай хамт өвөр монголын хөдөө орон нутгаар хээрийн судалгаа хийж, тухайн бүс нутгийн онцлогтой бүжгийн бүтээл туурвих үйл хэргийг эхлүүлсэн байна. Жя Зуо Гуан хээрийн судалгаандаа тулгуурлан Эвэнк үндэстний ахуй амьдрал, үндэстний сэтгэлгээ, өвөрмөц соёлыг тусгасан бүжгийн бүтээлүүд туурвисан юм. Түүний бүжгийн бүтээлийн гол сэдэв ба зохиомж нь Эвэнкчүүдийн шүтлэг бишрэл, ой шугуй, цаа буга, ан агнуурын

соёлтой холбоотой байв. Жя Зуо Гуаны бүжгийн бүтээлүүд нь Эвэнк үндэстний бүжгийн уламжлал тайзны урлаг руу шилжих шилжилтийн бэлгэ тэмдэг болсон билээ.

Нэрт бүжиг дэглээч Жа Зуо Гуаны дэглэсэн Эвэнк бүжгийн бүтээл. XX зууны 50-аад оны дунд үед Жя Зуо Гуан “Солон бүжиг”, “Эвэнк залуус” гэсэн бүжиг дэглэсэн нь тайзнаа тоглосон анхны Эвэнк бүжгийн бүтээл болсон юм. Өвөр монголын дуу, бүжгийн чуулгад 12 бүжигчин (6 эрэгтэй, 6 эмэгтэй) оролцсон олуул бүжиг. Тус бүжигт Эвэнк залуучуудын шинэ эриний эрч хүч, эв нэгдлийг харуулахдаа уламжлалт ан агнуурын соёлтой уялдуулсан байна. Мөн цаа буга маллах, хус модны үйсээр эд хэрэглэл хийх зэрэг ажил хөдөлмөр, Эвэнк хуримын зан үйл, хувцасны соёл, түүдэг галын бүжгийг тусгасан ажээ. “Эвэнк залуус” бүжгийг уламжлалт соёлыг тод томруун харуулж чадсан шилдэг бүжгийн бүтээл болсон гэж үздэг.

Жя Зуо Гуаны 1976 онд дэглэсэн “Солонго” хэмээх дан эмэгтэйчүүдийн олуул бүжиг бол өнөө ч тайзнаа тоглогдож байгаа шилдэг уран бүтээл болно. “Солонго” нь Эвенкийн ардын дуунд домог, уран бүтээл, шүтлэг бишрэл, сайн сайхны бэлгэдэл болж уламжлагдсаар ирсэн байна. Жя Зуо Гуан Эвэнк соёлын бэлэгдлийг сайтар судалж, ардын бүжгээс санаа авч, уран сэтгэмжийн дүрээр баяжуулан дэглэсэн бүжиг юм (Зураг 1). “Солонго” бүжгийн хөдөлгөөнийг задлан шинжлэхэд, Эвэнк ардын “Аханбай” болон “Барсын бүжиг”-ийн хөдөлгөөнд тулгуурласан байна. “Аханбай” бол Эвэнкчүүдийн дунд өргөн дэлгэрсэн ардын бүжиг. “Аханбай” гэдэг бас “Нүргэл” гэдэг “галын дөл бадрах”, “галын дөл дүрэлзэх” гэсэн үгнээс гаралтай. “Аханбай” бүжгийг цагаан сар, ураг хуримын өдөр охид бүсгүйчүүд гоёлын хувцсаа өмсөж, хуран цугларсан зочдын өмнө дуулан бүжиглэдэг байжээ. “Барсын бүжиг” нь Хөлөнбуйрын Эвэнк хошууны Хүй голын бүс нутагт амьдран суудаг Солон Эвенкийн дунд тархсан эмэгтэйчүүдийн бүжиглэдэг ардын бүжиг юм. Уг бүжигт барын ааш араншин, дүр төрхийг илэрхийлэхийн дээр барьсан идшээ булаалдах, хазалцах зэрэг үйл хөдлөл ордог байна.

Хүснэгт 1. “Солонго” бүжгийн уламжлал, шинэчлэлийн харьцуулалт

Ангилал	Уламжлал		Шинэчлэлт
Бүжгийн нэр	“Аханбай” бүжиг	“Барс” бүжиг	“Солонго” бүжиг
Утга агуулга	Галын дөл дүрэлзэх, наргиж хөөрөх	Барын дүр төрх, зан араншин, идшээ булаалдах	Эвэнкчүүдийн аз жаргалтай, амгалан тайван амьдрах хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн.
Бүжгийн хөдөлгөөн	Үсээ самнах, толинд харах, ханцуйгаа шуух, гараа сажлах зэрэг хөдөлгөөн байдаг.	1. Хоёр хүн өөд өөдөөсөө харан хоёр гараа өвдөг дээрээ тавьж суун үсрэх 2. Хоёр хүн идшээ булаалдах дүр байдал үзүүлнэ.	1. Гараа өвдөг дээрээ тавьж үсрээд хөлөө хажуу тийш өргөх 2. Нэг гараа дээш тэнийлгэн өргөж, нөгөө гараа мөрөндөө авч алхаж үсэрнэ.

Хувцас засал 	Солонг Эвэнкийн уламжлалт хувцас нь энгэр дээрээ үүлэн хээтэй, хормойн хоёр талдаа оноотой бөгөөд үүлэн хээтэй байдаг.	Уламжлалт хувцасны загвараас санаа авч шинэчлэхдээ хормойг нь өргөн уужуу найман талтай болгосон бөгөөд эмэгтэй бүжигчид хөх, улаан, шар, ягаан зэрэг солонгын долоон өнгийн хувцастай.
---	---	--

“Солонго” бүжиг нь Эвэнк бүжгийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн. Дараа дараагийн бүжиг дэглээч нарын дэглэсэн Эвэнк бүжигт тус бүжгийн намба төрх, хөдөлгөөнөөс санаа авсан зүйлс ажиглагддаг. “Солонго” бүжгийн амжилт нь “ардын язгуур бүжгийн арвин өв сангаас зохистой, уран яруу элементүүдийг шилж, тайзны бүжгийн техник, дэгээр баяжин, үйл явдалт бүжгийн хэлээр илэрхийлжээ” (Цэцэгжаргал 2023, 94). Шинэ үеийн бүжиг дэглэлтийн арга барилыг ашиглаж уламжлалт бүжгийн намба төрх, хөдөлгөөнийг шинэчлэн баяжуулж Эвэнк үндэстний бүжгийг орчин үеийн хэв маягтай болгосонд оршино. Тус бүтээл нь Эвэнк үндэстний шинэ амьдралыг магтан дуулж, цаг үеийн онцлогтой үндэстний сэтгэлгээг харуулж чадсан.



Зураг 1. “Солонго” бүжиг. (Бээжингийн Бүжгийн дээд сургууль 2023)¹

Орон нутгийн “Улаан мөчир”-ийн Эвэнк үндэстний бүжгийн бүтээл. 1950, 1960-аад оноос БНХАУ-ын ӨМӨЗО-ны хөдөө орон нутагт “Улаан мөчир” хэмээх урлагийн байгууллагууд байгуулагдаж эхэлсэн байна. Энэ нь Өвөр монголын малчин ард түмэнд соёл, урлагаар үйлчлэх, соён гэгээрүүлэх зорилготой уран сайхны чуулга юм. 1960-аад оноос Хөлөнбуйр аймгийн Дуу, бүжгийн чуулга,

¹ “Манай Жя Зуо Гуан” Тал нутагт буцаж ирлээ: “Ард түмэнд зориулсан бүжиг”- Жя Зуо Гуаны мэндэлсний 100 жилийн ойд зориулсан бүжгийн тусгай тоглолт Үндэсний XIV бүжгийн наадмаар амжилттай нээгдлээ. 2023.7.11. <https://mp.weixin.qq.com/s/hvHbbnoM3i6cx-z8Ixtiw>.

Эвэнк хошууны Улаан мөчир, Гэгээн хотын Улаан мөчир зэрэг Эвэнк үндэстнүүд оршин суудаг орон нутгийн урлагийн байгууллагад Эвэнк үндэстний бүжиг тоглох болжээ.

1978 онд Сүн Пэйжэнь, Фан Чэнлит нарын дэглэсэн Хөлөнбуйрын дуу, бүжгийн чуулгын бүжигчдийн бүжиглэсэн “Эвэнкийн хавар” олуул бүжиг залуусын золбоо хийморийг илтгэсэн хурдан цоглог бүжиг юм. Уг бүжигт уламжлалт “Барсын бүжиг”-ийн үндсэн хөдөлгөөн болон нэг хөлөөр товших хөдөлгөөн орсон байна. Тус бүжиг нь нүүдэлчин Эвэнкийн аж амьдралыг шууд тусгасан болно. Бүжигчдийн техник, ур чадварыг харуулсан өсгийдөх, солбин үсрэлт, хөлөө дэвсэх, гар сажлах, тохой өргөж дарах зэрэг хөдөлгөөнийг шинэчилж оруулсан байна.

Бүжиг дэглээч Одонгоогийн 1992 онд дэглэсэн “Эвэнк охин ба буга” бүжиг бол Эвэнк үндэстний бүжгийн хөгжилд түүхэн ач холбогдолтой бүтээл болсон юм. Цаа буга маллах соёлоос сэдэвлэсэн тус бүтээлд Эвэнк охидын цаа бугатайгаа харилцаж байгааг бүжгийн хэлээр илэрхийлсэн. Тус бүжгийг “... бугын алхаа гишгээ, явдлаас тусгаж авсан хөлийн хөдөлгөөнийг модерн бүжгийн газраар хийх хөдөлгөөний техниктэй (floor work) уялдуулан шинэлэг зохиомжийн аргаар дэглэжээ” (Ло Бин 2003, 56). Энэхүү бүтээл нь Эвэнк үндэстний соёлын мөн чанарыг харуулж чадсанаас гадна үндэстний бүжгийг хөгжүүлэх шинэ замыг нээсэн гэж үзэж болно. “Эвэнк охин ба буга” бүжиг нь хятадын цөөнх үндэстний бүжгийн шилдэг жишээ болсон бөгөөд 1994 онд Японд болсон “Номхон далайн уугуул үндэстний урлагийн наадам”-д тоглосноор олон улсад танигдсан билээ.

2020 онд Эвэнк үндэстний өөртөө засах хошууны Улаан мөчир чуулгын бүжиг дэглээч И Мингийн дэглэсэн “Эртний дурсамж” олуул бүжиг нь Эвэнк үндэстний уламжлалт соёл, итгэл үнэмшил, түүхэн дурсамжийг харуулсан бөгөөд эрт урьдын ёс уламжлал, галын шүтлэг бэлгэдлийг илэрхийлж, Эвэнк ардын бүжиг “Аятан” болон “Аханбай” бүжгийн хөдөлгөөнд тулгуурласан болно. “Аятан” бүжиг нь хоёр гахайны тэмцэлдэж байгааг дүрслэн харуулсан уламжлалт бүжиг бөгөөд Эвэнк үндэстний ан агнуур хийж байсан үеэс үүссэн бүжиг юм. “Эхлээд хоёр эрэгтэй бүжигчин бие биедээ ойртон нэг гарны нударгаа зангидан бие биенийхээ өөдөөс дайрна. Дараа нь хоёр гараа өвдөг дээрээ тавин өвдгөө нугалан язгуурын суулт, мөрөө солбиж цохилгоо тэмцэлдэх байдалд орж, зодолдох дүрийг харуулна (Лүэ 2007).

2020 онд Эвэнк үндэстний өөртөө засах хошууны Улаан мөчрийн бүжиг дэглээч Чүнмэй дэглэсэн эмэгтэй олуул бүжиг “Аханбай” малчин Эвэнк эмэгтэйчүүдийн нүүдлийн аж амьдрал ажил хөдөлмөрийг тусгасан сэдэвт бүтээл нь малчдын амьдрал ахуй, өдөр тутмын үйл ажиллагааг харуулахыг зорьсон бүтээл юм. Бүжиг дэглээч бүжиг найруулахдаа, ардын урлагчин “Аханбай” бүжгийн өвлөн залгамжлагч Сүрэнгуа настнаас сурвалжилга авч, уламжлалт үндсэн хөдөлгөөн суралцаж бүжигт оруулсан юм (Зураг 2). Бүжгийн хөдөлгөөний элемент нь ардын “Аханбай” ба “Барсын” бүжгийн үндсэн хөдөлгөөн юм. Гараа сажлах, хөлөөр товших, толгойгоо сажлах зэрэг хөдөлгөөнийг шингээн, шинэ нийгэмд малчид баяр баясгалантай хөдөлмөрлөж байгааг илэрхийлсэн байна.



Зураг 2. Аханбай бүжиг (Хөлөнбуйр хотын соёл, аялал жуулчлал, радио, кино, телевизийн газар 2021)²

Хүснэгт 2. Орон нутгийн “Улаан мөчир”-ийн бүжгийн харьцуулалт

Бүтээлийн нэр	он	Бүжиг дэглээч	Сэдэв ба агуулга	Бүжгийн онцлог ба шинэлэг тал
Эвэнкийн хавар	1978	Сүн Пэйжэнь, Фан Чэнли	Эвэнк залуучуудын хайр дурлал, хөдөлгөөнт амьдралыг илэрхийлсэн.	Уламжлалт “Барсын бүжиг”-ийн нэг хөлөөр үсрэх хөдөлгөөн, орчин үеийн техник (үсрэлт, эргэлт, гар сунгалт) нэмсэн.
Эвэнк охин ба буга	1992	Одонгоо	Эвэнк охид болон бугын харилцааг дүрсэлсэн.	Бугын алхаа, орчин үеийн “floor work” техникийг хослуулсан.
Эртний дурсамж	2020	Имин	Эвэнкийн нүүдэлчдийн шүтлэг, түүхэн дурсгалыг бэлгэдэлчлэн харуулсан.	Уламжлалт “Аятан” (гахайн бүжиг), язгуурын суулт, мөрөн солбиж, цохилгоо тэмцэлдэх байдалд “Аханбай”-н хөдөлгөөн гарын нударгаа зангидан цээж өөд сажлах.
Аханбай	2020	Чүнмэй	Эвэнк эмэгтэйчүүдийн өдөр тутмын аж амьдрал, мал аж ахуй	Уламжлалт “Аханбай”, “Барсын бүжиг”-ын хөдөлгөөн (гар савлах, хөл товших)

ӨМӨЗО-ны Урлагийн дээд сургуулийн бүжгийн багш нарын дэглэсэн Эвэнк бүжгийн бүтээл. Эвэнк үндэстний бүжгийн урлагийн хөгжилд Өвөр монголын урлагийн дээд сургуулийн бүжгийн багш, дэглээч нар зохих хувь нэмрээ оруулжээ. Профессор Жо Лин Пиний 2006 онд дэглэсэн “Эвэнк янзага”, бүжгийн багш, дэглээч Ян Жин Жин, Э Жин Жин нарын 2009 онд дэглэсэн “Эвэнк Унааж” хэмээх хоёр бүтээл нь Эвэнк үндэстний бүжгийн зохиомжид шинэчлэлт хийж тогтсон намба төрхийг өөрчлөн өвөрмөц хэв маяг бий болгосон юм.

² “Хятадын Эв хамт Нам байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан Хөлөнбуйр хотын Улаан Морьт цуврал тоглолтын арга хэмжээ” 2021.06.03

“Эвэнк янзага” хэмээх гоцлол бүжигт өглөө сэрээд ой дотор эрх дураараа баясан гүйж, зугаацан тоглож байгаа сэргэлэн цовоо янзаганы дүрийг бүтээжээ. Үүрийн гэгээ орох үест нойрноосоо сэрж буй янзага гар, бугуй, мөр, цээжийг хөнгөн зөөлнөөр сунгаж, сунайж байгаа дүр зургаар эхэлдэг. Улмаар ой дотор зугаалж, усаар тоглож, чөлөөтэй гүйж буй янзаганы дүрээр амьдралын баяр баясал, эрч хүчийг харуулдаг.



Зураг 3. “Эвэнк янзага” бүжиг (Өвөр монголын урлагийн дээд сургууль, 2006)³

Тус бүтээл нь хүмүүсийн үзэж дассан бугын дүрийг илэрхийлсэн бүжгээс эрс ялгаатай болсон юм. Тус бүжгийн зохиомжид өмнөх үеийн Эвэнк бүжигт орж байгаагүй дэглээч шинэ арга зам эрэлхийлж, эргэлт, үсрэлт зэрэг хөдөлгөөний оруулсан нь бүжигчний техник ур чадварыг хөгжүүлэн баяжуулсан юм. “Эвэнк янзага” бүжгийн малгайг уламжлалт бугын малгайтай төстэй хийсэн бол бүжигчний биеийг барьсан хувцас нь бүжигчийн би бялдрыг тодруулж өгчээ. Уг бүжигт эргэлт, үсрэлт харьцангуй их орсон тул зөөлөн ултай гуталтай байв (Зураг 3).

Өвөр монголын урлагийн дээд сургуулийн бүжгийн багш, дэглээч Ян Жин Жин болон Э Жин Жин нарын дэглэсэн “Эвэнк Унааж” олуул бүжиг нь “Олгуяа” Эвэнк охидын эелдэг зан төрх, цаа бугатайгаа тоглож буй дүр зургийг харуулжээ. “Унааж” гэдэг нь Эвэнк хэлний “охин” гэсэн утгатай үг аж (Зураг 4). Тус бүжгийн бугын дүр төрхийг илэрхийлсэн хөнгөн үсрэлт болон бугын эврийг дүрсэлсэн гарын барилт нь “Эвэнк янзага”-тай төстэй. Мөн уламжлалт нэг хөлөөр товших, хоёр гараа сажлах хөдөлгөөнийг оруулахдаа байрандаа хийдэг байсан хөдөлгөөнийг явалттай болгож эрчмийг нь нэмж өгснөөр цаа бугын сүргийн сүр жавхаа, дүр төрхийг тодотгоход чухал үүрэг гүйцэтгэжээ.

Бугын дүрийг илэрхийлсэн хувцсыг “Эвэнк янзага” бүжгийн хувцастай адилавартай байдлаар шийдсэн байна. Тус бүжгийн гол дүр болох охины хувцсыг Эвэнкийн уламжлалт хувцасны загварыг бүжгийн онцлогт тохируулан шинэчлэхдээ зах, ханцуй, хормойг нь олон өнгийн бүсээр эмжиж өгчээ.

³ Хэ Жиан 8 дахь удаагийн Таоли худагт үндэсний ардын бүжиг “Эвэнк янзага” эмэгтэй гоцлол бүжиг. 2006.8.18 <https://www.bilibili.com/video/BV1qt4y197LL/>



Зураг 4. “Эвэнк Унааж” бүжиг (Ян Жин Жин 2007)

“Эвэнк янзага”, “Эвэнк Унааж” гэсэн хоёр бүжгийн янзага, бугын хувцсыг бүтээхдээ орчин үеийн хувцас загварын онцлогийг шингээж бүжигчний биеийг барьсан, нэг талын мөрийг нь ил гаргасан нь байдлаар шийдсэн нь ижил төстэй байна. Дараах хүснэгтээр хоёр бүжгийн нийтлэг болон онцлог талыг харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 3. Хоёр бүжгийн харьцуулалт

Шинжилгээний хүрээ	“Эвэнк янзага”	“Эвэнк Унааж”	Нийтлэг тал
Бүжгийн хэлбэр	Эмэгтэй бүжигчин тоглосон гоцлол бүжиг	Эмэгтэйчүүдийн олуул бүжиг, гоцлолтой.	Эмэгтэй бүжигчин бүжиглэсэн.
Бүжиг дэглээч	Жао Лин Пин	Ян Жин Жин, Э Жин Жин	Өвөр монголын Урлагийн дээд сургуулийн багш
Дэглэсэн он	2006	2009	
Хөдөлгөөний онцлог	Хэм хэмнэлт	Урсам	
Утга агуулга	Эвэнк янзаганы зан төрх, амьдралын баяр баясал, эрч хүчийг харуулсан.	Эвэнк охины цаа бугатайгаа тоглож буй харилцааг харуулсан.	Эвэнкийн цаа бугын соёлыг гол бэлгэдэл болгосон.

Хэлэлцүүлэг

Аливаа үндэстний бүжгийн урлагийн уламжлал, шинэчлэлийн асуудал нь бүжиг судлалын нэг чухал сэдэв мөн. Эвэнк үндэстний бүжгийн судалгаа нь гол төлөв ардын бүжгийг судлахад чиглэж иржээ. Бүжиг судлаач Жи Лан Вэй, Чиу Жиу Рун нар “БНХАУ-ийн цөөн тоот үндэстний бүжгийн түүх” (2003) номдоо Эвэнк ардын бүжгийн гарал үүслийг судлан бичсэн бол Лүэ Ян Чин нь “Хөлөнбуйрын ардын бүжиг” (2007) бүтээлдээ Эвэнк ардын бүжгийн агуулга,

дуу хөгжим, бүжгийн зураглал, хөдөлгөөн, хувцаслалтын онцлогийг авч үзжээ. Бүжгийн багш Цэцэнтархи “Монгол үндэстний бүжгийн үндсэн дасгал” (2008) сурах бичигтээ Эвэнк бүжгийг заах аргачлалыг бичсэн бол судлаач Жан Шиан Тин “Малчин Эвэнкийн бүжгийн соёлыг хамгаалах, хөгжүүлэх судалгаа” (2017) өгүүлэл бичжээ.

Venera Marfusalova болон бусад эрдэмтэд “Хойд нутаг дахь ардын уламжлалт дуу бүжиг урлаг (Эвэнкийн тойрон бүжигтэй холбон)” (Traditional song and dance art of the peoples of the North (on the example of round dances of the Evenks)) (2019) гэдэг өгүүлэлдээ ОХУ-ын Эвэнкийн тойрон бүжгийг судалж, түүний түүхэн гарал (ан агнуур, шашны ёслолтой холбоо), dehvehjdeh, gosugor зэрэг олон төрлийн бүжгийн ялгаа, Якуттай харилцан нөлөөлөл, орчин үеийн соёлын дахин сэргэлтийг онцолсон. Энэхүү бүжиг нь Эвэнкийн соёлын “амьд үлдэц” бөгөөд нийгмийн нэгдэл, байгальтай уялдаатайг илтгэдэг. А.Н.Мальчакизовын “Эвэнкийн хэл, аман зохиолын дуу бүжгийн урлаг” (Песенно-танцевальное искусство в языке и фольклоре эвенко) (2020) судалгааны өгүүлэлд ОХУ-ын Эвэнкийн соёлын гарал үүсэл, хэлний дуу бүжгийн урлаг, аман зохиолын асуудлыг судалсан байна.

Харин орчин цагийн БНХАУ-ын Эвэнк тайзны бүжгийн талаарх судалгаа хомс байгаа бөгөөд судлаач Жао Сяодингийн “Зуа Гуаны бүжгийн уран бүтээл, тавилга дээрх уран чадварын онцлогийн шинжилгээ” гэсэн өгүүллээс өөр бүжгийн бүтээлийн уламжлал, шинэчлэлийг авч үзсэн судалгааны дорвитой бүтээл байхгүй байна. Орчин цагийн Эвэнк бүжгийн бүтээлийг судалж, дүн шинжлэл хийх замаар үе үеийн уран бүтээлчдийн уламжлалыг хэрхэн шинэчилсэн арга, туршлагыг нээн илрүүлэх нь цаашдын хөгжлийн төлөвийг тодорхойлоход чиг баримжаа болох ач холбогдолтой юм.

Орчин цагийн Эвэнк үндэстний бүжиг үүсэж хөгжсөн 70 гаруй жилийн хугацаанд төв, орон нутгийн урлагийн байгууллагын тайзнаа Эвэнк бүжгийн бүтээл тоглосоор ирсэн билээ. Эвэнк бүжиг нь үндэстний соёлыг хадгалан хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн нь илэрхий байна.

Судалгаанаас үзэхэд, 1950-1970-аад оны үед дэглэсэн ихэнх бүжгийн бүтээлүүд тоглохоо больсон нь ажиглагдсан юм. Цаашид энэ асуудлын учир шалтгааныг нь тодруулах, урын санг хадгалах, үе үеийн төлөөлөх чанартай шилдэг бүтээлийг тайзнаа сэргээн тавих шаардлагатай байна.

Эвэнк ардын бүжгийн уламжлалыг орчин цагийн тайзны бүжиг дэглэх онол, арга зүйн дагуу шинэчлэн хөгжүүлсэн билээ. Тэгвэл өнөө цагт уламжлал, шинэчлэлийн залгамж чанарыг хадгалж өмнөх үеийн бүжиг дэглэгчдийн бүтээлийн уламжлалд суурилан өнөө цагийн үзэгчдийн гоо сайхны таашаалд нийцүүлэн шинэчлэх нь Эвэнк үндэстний бүжгийг хөгжүүлэх зүй тогтол гэж үзэж байна.

Дүгнэлт

БНХАУ-ын Эвэнк үндэстний орчин цагийн тайзны бүжиг нь уламжлалт соёл, ард түмний ахуй амьдралтай нягт холбоотой ардын бүжгийн хөрсөн дээр үүсч хөгжсөн байна. БНХАУ-ын төрийн бодлого нь уран бүтээлчдэд үндэстний урлагийн өвийг судлах, судалгаандаа тулгуурлаж тайзны бүтээл туурвих нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

1954 онд Жяо Зуа Гуаны дэглэсэн “Солон бүжиг” нь тайзнаа тоглосон анхны Эвэнк бүжиг байсан бөгөөд түүнээс хойш төв, орон нутгийн урлагийн байгууллагад олон тооны бүжгийн бүтээл туурвисаар иржээ. Нэрт бүжиг дэглээч Жяо Зуа Гуан уламжлал, шинэчлэлийг хослуулан дэглэсэн бүжгийн бүтээлүүдээрээ Эвэнк үндэстний орчин цагийн тайзны бүжгийн суурийг тавьж өгчээ. Түүний баттай суурилуулж өгсөн Эвэнк үндэстний бүжгийн намба төрх, хөдөлгөөнийг дараа дараагийн бүжиг дэглэгчид уламжлан хөгжүүлсэн байна.

Төвийн төдийгүй Эвэнк үндэстэн оршин суудаг орон нутгийн мэргэжлийн уран бүтээлчид Эвэнк бүжгийг цаашид хөгжүүлжээ. Ялангуяа Одонгоогийн дэглэсэн “Эвэнк охин ба буга” нь модерн бүжгийн арга техникийг бүжгийн зохиомжид нэвтрүүлсэн шинэлэг бүтээл болсон байна.

Өвөр монголын Урлагийн дээд сургуулийн багш Жо Лин Пиний дэглэсэн “Эвэнк янзага”, Ян Жин Жин, Э Жин Жин нарын дэглэсэн “Эвэнк Унааж” хэмээх өвөрмөц хэв маягтай бүтээлүүд нь Эвэнк үндэстний бүжгийн урын сан баяжуулж өгчээ.

Эвэнк үндэстний бүжгийг хөгжүүлэхэд уламжлал ба шинэчлэл хоорондын шүтэлцээг тэнцвэртэй хадгалах нь зайлшгүй шаардлагатай. Өмнөх үеийн бүжиг дэглэгчдийн бүтээлүүд нь соёлын өвийн чухал бүрэлдэхүүн бөгөөд тухайн цаг үеийн гоо зүйн нийцүүлэх шинэчлэл нь бүжгийн урлагийн хөгжилд дэмжлэг болох ч, түүхэн болон угсаатны онцлогийг алдагдуулах аюултай. Жишээ нь, уламжлалт бэлгэдэл, зан үйлийн утга алдах, хөдөлгөөний бүтэц, зохиомж эвдэх зэрэг болно. Иймд шинэчлэлийг “хөгжил” гэж үзэхийн зэрэгцээ, өв соёлыг хадгалах, түүх, угсаатны зүй, гоо зүй, бүжгийн урлагийн онолын үндэслэлтэйгээр явагдах нь зүйтэй.

Ардын бүжгийг уламжлан хөгжүүлж, үндэстний соёлыг тайзнаа амьдруулсанд Эвэнк үндэстний орчин цагийн бүжгийн үнэ цэн оршиж байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

Ашигласан материал

Жао Сяодин. 2011. “Зуа Гуаны бүжгийн уран бүтээл, тавилга дээрх уран чадварын онцлогийн шинжилгээ.” *Том тайз* (Хэбэй урлагийн хүрээлэн).

Ло Бин. 2003. *Орчин үеийн бүжгийн шинэчлэл*. Бээжин: Урлагийн хэвлэл.

Лүэ Ян Чин. 2007. *Хүлэнбуйрын ардын бүжиг*. Хөх хот. Өвөр монголын Соёл хэвлэлийн газар

Содном, Н., Гэрэл, Б. 2023. *Барга, Буриад, Эвэнк, Орчоон угсаатны соёл, урлагийн судалгаа*. Улаанбаатар: Мелон хэвлэх үйлдвэр.

Сэрэнбат. 2007. “Эвэнк хэл ба монгол хэлний харьцуулсан судлал.” Ph.D дисс. Өвөр монголын их сургууль.

Цэцэгжаргал, Т. 2023. “Бүжгийн дүрийн талаарх эргэцүүлэл.” *Урлаг судлалын форум III Урлаг: Уламжлал ба орчин үе*. Ред. Алтанцэцэг Ч. Улаанбаатар.

Хань Шяочин, Жао Чуань. 2021. “Зуун цэцэгс зэрэг дэлгэрч, зуун урсгал зэрэг өрсөлдөх - Соёлын хүчирхэг гүрэн байгуулах, Хятадын мөрөөдлийг бүтээх.” *Шинжсинг бао сонин*. 2025.05.25. <https://baijiahao.baidu.com>.